



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 08 өдөр

Дугаар А/759

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.4, Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8 дахь заалт, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 дугаар тушаалыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгалийн нөөц баялаг ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэн Алтай, Дарви сумын нутагт үйл ажиллагаа явуулж буй “Талст молор” ХХК-ийн “Оцог хад” гянтболдын, “МоЭнКо” ХХК-ийн “Хөшөөт”-ийн нүүрсний уурхайн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, дүгнэлт гаргах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Б.Баярсүх - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

Гишүүд: Н.Алтанцэцэг - Мэргэжлийн хяналтын газрын байгаль орчин, геологи уул уурхайн хяналтын улсын байцаагч

Х.Мөнхжаргал - Мэргэжлийн хяналтын газрын байгаль орчны хяналтын улсын байцаагч

А.Ганцоож - Мэргэжлийн хяналтын газрын байгаль орчны хяналтын улсын байцаагч

Т.Бямбажаргал - Байгаль орчин, аялал жуулчлалын газрын усны асуудал хариуцсан мэргэжилтэн

Б.Мөнхбат - Үенч-Бодонч-Булган голын сав газрын захиргааны ус ашиглалт хариуцсан мэргэжилтэн

- Н.Жавхлантөгс - Хүйсийн говь Цэцэг нуурын сав газрын захиргааны ус ашиглалт хариуцсан мэргэжилтэн
- Э.Оюунтунгалаг - Хар нуур Ховд голын сав газрын захиргааны ус ашиглалт хариуцсан мэргэжилтэн
- Х.Түмэндэлгэр - Алтай сумын Засаг дарга
- С.Долгормаа - Алтай сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч
- Б.Мөнхцэцэг - Алтай сумын байгаль хамгаалагч
- Нөлөөллийн бүсэд оршин сууж буй иргэдийн төлөөлөл
- О.Ганцоож - Дарви сумын Засаг дарга
- Н.Батболд - Дарви сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч
- Б.Бум-Эрдэнэ - Дарви сумын байгаль хамгаалагч
- С.Жамбалдорж - Нөлөөллийн бүсэд оршин сууж буй иргэдийн Төлөөлөл
- Нөлөөллийн бүсэд оршин сууж буй иргэдийн төлөөлөл

Нарийн бичгийн

дарга: Б.Ариундолгор - Байгаль орчин, аялал жуулчлалын газрын газрын хэвлий, нөхөн сэргээлт, байгаль орчны нарийвчилсан байдлын үнэлгээний асуудал хариуцсан мэргэжилтэн

2. Байгалийн нөөц баялаг ашиглан үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудын тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу хяналт тавьж, дүгнэлт гаргах ажлыг 2021 оны 12 дугаар сарын 15-ны дотор зохион байгуулж гарсан үр дүнг танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагчид даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН